

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: АГГ-2022/16-ШТА-ГА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
газар

Дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр

Утас: 70483413

Цахим хаяг:

Tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Цэцэгмаа

Цахим хаяг: Tsetsegmaab@audit.gov.mn

Аудитор Г.Энхдэлгэр

Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn

Аудитор Б.Цэвэлмаа

Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn

ТАЙЛАНТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙГ WWW.TAILAN.AUDIT.MN ЦАХИМ ХАЯГААР
АВНА УУ.

АЛТАЙ ХОТ 2022 ОН



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠒ оны ᠐4 сарын ᠒9 өдөр

Дугаар 709

Алтай хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөгчдийн хурал, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

Х.ТҮВШИНБАЯР

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторовын
2024 оны 04 дугаар сарын 29-ны
өдрийн 709 дугаар тушаалын хавсралт

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

ДД	Хариуцагч	Товч утга	Дугаар	Зөрчлийн дүн /сая.төгрөг/	8217 Аудитын нэр ДЮА0060 5018301
1	Аймгийн Засаг дарга	Төлбөр барагдуулах тухай	01/116	5.1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2	Аймгийн Засаг дарга	Төлбөр барагдуулах тухай	02/116	6.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
3	Аймгийн Засаг дарга	Төлбөр барагдуулах тухай	03/116	89.6	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
4	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	01/196	2,293.4	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
5	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	02/196	0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
6	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	03/196	112.5	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
7	Тонхил сумын ЕБС	Зөрчил арилгуулах тухай	04/196	49.5	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
8	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	05/196	0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
9	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	06/196	0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
10	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	07/196	28.9	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
11	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	08/196	18.6	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
12	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	09/196	32.0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
13	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	10/196	32.3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
14	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	11/196	0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
15	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	12/196	8.8	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
16	Орон нутгийн өмчийн газар	Зөрчил арилгуулах тухай	13/196	186.7	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
	Нийт дүн			2,863.4	

Агуулга	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
Хүснэгтийн товъёг	4
Зургийн товъёг	4
АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ, ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ	5
АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	5
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	6
А.1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	8
А.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь аймгийн богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан байна.	8
А.1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнээс 7 төсөл, арга хэмжээ нь аймагын төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүй байна.	8
А.2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ТҮҮНД МАГАДЛАЛ ХИЙХ ТОГТОЛЦООГ БАРИМТЛААГУЙ БАЙНА.	8
А.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг орон нутгийн хэрэгцээ шаардлага, инженер геологийн дүгнэлт, бусад холбогдох техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэргийг үндэслэж иж бүрэн боловсруулаагүйгээс 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, хэрэгжилт удаашралтай 1 төсөл, арга хэмжээ байна.	8
А.2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд боловсруулж, баталгаажуулсан байна.	9
А.2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад олгосон зардлыг бодит гүйцэтгэл болон зургийн жишиг үнийг үндэслэсэн байна.	9
А.3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ҮР АШИГТАЙ ТӨЛӨВЛӨХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	10
А.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнд хэрэгцээ шаардлагагүй, эсвэл хэрэгцээ шаардлагаас бага болон их хүчин чадалтай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.	10
А.3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг анх батлахдаа төсөвлөлтийн шаардлагыг хангаагүйгээс тус төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх, хэрэгжих явцдаа төсөвт өртөг нэмэгдэх, эх үүсвэр хүрэлцэхгүй царцах гэх мэт сөрөг үр дагавар үүсгэсэн байна.	10
А.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулаагүй байна.	11
А.3.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулаагүй байна.	11
Б.1. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГАА ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.	11
Б.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.	11
Б.1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг тайлант онд хэрэгжих боломжийг хангах хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.	12

Б.1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулж, батлуулж хэрэгжүүлсэн байна.	12
Б.1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.	13
Б.1.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнаж, шилэн дансаар дамжуулан нийтэд мэдээлсэн байна.	13
Б.2. ЗАХИАЛАГЧ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ҮР ДҮНТЭЙ ХАНГУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖИЛ ДУТМАГ БАЙНА.	13
Б.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн ажлын гүйцэтгэл дуусаж хүлээн авсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, төсвөөр захиалагчтай байгуулсан гэрээний дагуу үр дүнтэй гүйцэтгэсэн боловч ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг дахин засварлуулах шаардлагатай байна.	13
Б.2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналт үр дүн багатай байна.	16
Б.2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн техник, тоног төхөөрөмж хэрэглэгчид бүрэн хүрсэн байна.	16
Б.2.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдаж хийгдсэн боловч ажлын гүйцэтгэл, чанараас шалтгаалан хүлээн аваагүй 5 төсөл арга хэмжээ орхигдсон байна.	16
Б.3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮҮ?	17
Б.3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдүүлээгүй байна.	17
Б.3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.	18
Б.3.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд ТЕЗ-ын дотоод аудитын нэгж хяналт шалгалт хийгээгүй байна.	18
Б.4 УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙН ЖИЛД БАТЛАГДСАН САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН АШИГЛАХ ЗОРИЛГООР ЗАСГИЙН ГАЗРААС ГАРСАН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	18
Б.4.1. Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний 1,614.7 сая төгрөгийн үлдэгдэл байршиж байна.	18
Б.4.2. Өмнөх онуудад Засгийн газраас ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгөөс гүйцэтгэгчид гэрээний дүнгээс илүү төлбөр шилжүүлсэн байна.	20
Б.5 УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН БАЙНА.	20
Б.5.1. Ашиглалтад хүлээн авсан 1 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.	20
Б.5.2. Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд болон он дамжин хэрэгжиж байгаа 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэнээс 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй орхигдсон байна.	21
Б.5.3. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт удаашралтай бодитоор гарсан үр дүн багатай байна.	21
Б.5.4. Улсын төсвийн хөрөнгөөр тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийгдээгүй.	23
Б.5.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөгөөр дэд бүтцийн салбарын хүчин чадал нэмэгдээгүй байна.	23
Холбогдох байгууллагын санал.	26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АШБ	Анхан шатны баримт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БШУСЯ	Боловсрол шинжлэх ухаан спортын яам
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗЗН	Засаг захиргааны нэгж
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГАА	Говь-Алтай аймаг
ГА	Гүйцэтгэлийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТАХ	Төсөл арга хэмжээ
ШТА	Шууд тайлагнах аудит
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
гүйцэтгэлийн аудитын тайлан

АГГ-2022/16-ШТА-ГА

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээ	7
Хүснэгт 2	ТАХ-ын судалгаа	11
Хүснэгт 3	Орхигдсон төсөл арга хэмжээ	16
Хүснэгт 4	Хураангуй	17
Хүснэгт 5	Олгосон санхүүжилт харьцуулалт	19
Хүснэгт 6	Харьцуулалт	21
Хүснэгт 7	Нэмж батлагдсан төсөв өртөг	21
Хүснэгт 8	Төсөвт өртөг нэмэгдсэнээр орхигдсон барилгын судалгаа	21

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Байршлын зураг	9
Зураг 2	Ажлын явц зурган харьцуулалт	19

**АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ, ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ,
АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

**Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

**Аудитын
зорилт**

“Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх
- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх

**Аудитын
хамарсан
хүрээ**

Аудитад аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймагт эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, газар дээрх нөхцөл байдалтай холбоотой төлөвлөлт хийсэн судалгаа шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, бий болсон өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалт холбоотой баримт материалыг хамруулан аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, төсөл арга хэмжээний ашиглагч байгууллагад байгаа баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

**Аудитын
хязгаарлалт**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайд Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, засгийн газар болон харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдын 2021 оны эрх шилжүүлсэн тогтоолын хүрээнд эрх шилжсэн төсөл арга хэмжээ болон өмнөх жилүүдэд чанар байдал хангалтгүй аудитаар шийдвэр өгсөн Дарив сумын ЭМТ, ЕБС, Баян-Уул сумын ЕБС, Дэлгэр сумын төвийн шинэчлэлийг хамруулсан.

**Аудитын
арга зүй,
шалгуур
зүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817:2020 3Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” MNS 6817:2020 3Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг

ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын
бүрэлдэхүүн
хугацаа**

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж стандартыг хангуулан, ахлах аудитор Б.Цэцэгмаа, аудитор Г.Энхдэлгэр, Б.Цэвэлмаа нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 2022 оны 4 дүгээр сарын 16-аас 2022 оны 4 дүгээр сарын 18-нд хийж аудитын тайланг 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

**Хүндрэл
бэрхшээл**

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн аудит хамрах хугацаанд 3 удаа солигдсон, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер 1 удаа солигдсоноос зарим төсөл арга хэмжээний байрлал тодорхойгүй, аудитад шаардлагатай баримт материал гаргаж өгөх процесс удаашралтай байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говь-Алтай аймаг нь 141 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй. Засаг захиргааны 18 сум 88 багт 16,521 өрхөд 58,343 хүн ам амьдарч байна.

Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 57.7 буюу 19,567 хүн ажил эрхэлж ДНБ 370,765.9 сая төгрөг болж өмнөх оноос 39,702.0 сая төгрөгөөр буурсан байна. Нийт ДНБ-ий 55 хувийг хөдөө аж ахуйн салбар, 13 хувийг үйлдвэрлэлийн салбар, 32 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлж байна. /Эх сурвалж: Статистикийн нэгдсэн мэдээллийн сан www.1212.mn /

Улсын Их Хурлаар 2020 онд баталсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан тодотголоор Говь-Алтай аймагт нийт 57,729.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээнд 24,770.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Батлагдсан арга хэмжээнд 2021 онд өмнөх оноос он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй 25 шинээр хэрэгжиж буй 12 төсөл, арга хэмжээ багтсан байна.

Манай аймагт хэрэгжихээр батлагдсан нийт төсөл арга хэмжээний 65 хувийг барилга байгууламжийн 35 хувийг их засварын төсөл арга хэмжээ эзэлж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан 8,480.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7,700.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 20 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Засгийн газар болон харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдын шийдвэрээр Говь-Алтай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгосон байна.

Эрх шилжиж ирсэн 630.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, хэрэгжсэн 17 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 5,578.1 сая төгрөгийг олгож, 79 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.14, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.3-т заасныг тус тус үндэслэн

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
гүйцэтгэлийн аудитын тайлан

АГГ-2022/16-ШТА-ГА

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдэл болох 1,343.2 сая төгрөгийг (100050000350) тоот барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалт нь улс орны эдийн засгийн өсөлт, хөгжлийг санхүүжүүлэх механизмыг бий болгодог. Манай аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ нь ирээдүйд ашиг орлого бий болгохоос илүү нийгмийн салбарын хэрэгцээ шаардлагыг хангах ашиг орлого олох зорилгогүй барилга байгууламж, их засварын ажил ажээ.

Хүснэгт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээ

БАТЛАГДСАН ҮЗҮҮЛЭЛТ/ ТӨЗ	сая.төг					
	БХБС	БШУС	ЗТХС	СС	ХНХС	ЭМС
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО	1	6	1	4	1	1
ШИНЭ		2		3		1
ШИЛЖИХ	1	4	1	1	1	
ТӨСӨВТ ӨРТӨГ	200.0	4,020.0	80.0	870.0	1,200.0	220.0
САНХҮҮЖИХ ДҮН	150	3,820.0	30.0	670.0	1,150.0	220.0
ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ /2021 ОН/	49.0	3,878.3	0	603.9	839.0	207.9

Эх сурвалж: Аудитын явцад хийгдсэн УТХО судалгаа

Шилэн данс: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

А.1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь аймгийн богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан байна.

Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийг улсын чиг хандлагатай нийцүүлэн хурдасгах, ядуурлыг бууруулж хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх зорилтод хүрэх гол арга зам нь хөрөнгө оруулалтын бодлогыг боловсронгуй болгож, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх асуудал юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ нь аймгийн богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигтэй нийцэж байгаа боловч цаашид хийгдэж байгаа хөрөнгө оруулалтад эдийн засгийн өсөлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд чиглэх хэрэгцээ шаардлага тулгарсан байна.

А.1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнээс 7 төсөл, арга хэмжээ нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүй байна.

Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудсыг ашиглалтад оруулж санхүүжилтийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”, 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төсөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-аар бүрдүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч талууд эрх зүйн зохицуулалтын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цахим системийг үйл ажиллагаандаа ашиглахаар байна. Аудитаар Говь-Алтай аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг www.publicinvestment.gov.mn веб хуудсанд бүрэн оруулаагүй, мэдээллийн систем зүгшрээгүй, хангалттай бус байна.

Дээрх вэб хуудаст оруулсан мэдээлэл буюу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг батлагдсан хуультай харьцуулахад санал илгээсэн 15 төсөл, арга хэмжээ батлагдаагүй, санал өгөөгүй 7 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

А.2. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ТҮҮНД МАГАДЛАЛ ХИЙХ ТОГТОЛЦООГ БАРИМТЛААГҮЙ БАЙНА.

А.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг орон нутгийн хэрэгцээ шаардлага, инженер геологийн дүгнэлт, бусад холбогдох техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэргийг үндэслэж иж бүрэн боловсруулаагүйгээс 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, хэрэгжилт удаашралтай 1 төсөл, арга хэмжээ байна.

Хуульд 2021 онд хэрэгжихээр батлагдсан харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдаас аймгийн Засаг даргад эрх шилжин шинээр хэрэгжиж байгаа ажлууд бүгд их засварын ажил байгаа тул энэ асуудалд хамаарахгүй байна.

Харин он дамжин хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний тухайд төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу газрын зөвшөөрөл гараагүй, техникийн нөхцөл олгогдоогүй, төсөл

хуульд тусгасан нь тайлант онд бүрэн хэрэгжүүлэх боломжгүйд хүргэсэн, инженер геологийн дүгнэлтгүйгээр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн зөрчил түгээмэл байна. Тухайлбал:

- ✓ **Газрын зөвшөөрөл олгогдоогүй ТАХ-ний тухайд:** Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /ГАА Есөнбулаг/, Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байршил /ГАА Есөнбулаг/.
- ✓ **Техникийн нөхцөл олгогдоогүй ТАХ-ний тухайд:** Ахмадын холбоо, сувиллын барилга /ГАА Есөнбулаг/, Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /ГАА Есөнбулаг/, Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байршил /ГАА Есөнбулаг/.
- ✓ **Инженер геологийн дүгнэлт гараагүй ажлын тухайд:** Ахмадын холбоо, сувиллын барилга /ГАА Есөнбулаг/, Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт/ГАА Есөнбулаг/, Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байршил /ГАА Есөнбулаг/.

Анх 2020 онд хуульд батлагдсан Нийтийн тээврийн автобусны буудал 10 байршил /ГАА Есөнбулаг/ төсөл, арга хэмжээ судалгаа тооцоололгүйн улмаас өнөөг хүртэл хэрэгжээгүй байдалтай байна.

Зураг.

Байршлын зураг

Анх 2020 онд хуульд батлагдсан Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /ГАА, Есөнбулаг/ төсөл, арга хэмжээний байршил тодорхойгүйгээс 2 байршилд ажил эхлээгүй, 1 байршилд цутгасан талбайн ажил хуулагдсан байна.



А.2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд боловсруулж, баталгаажуулсан байна.

Хуульд 2021 онд хэрэгжихээр батлагдсан харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдаас аймгийн Засаг даргад эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд боловсруулсан байдлыг <http://opendata.burtgel.gov.mn/> холбоосоор орж тулган баталгаажуулахад зураг төсөл боловсруулсан хуулийн этгээдүүд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

А.2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад олгосон зардлыг бодит гүйцэтгэл болон зургийн жишиг үнийг үндэслэсэн байна.

Хуульд 2021 онд хэрэгжихээр батлагдсан харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдаас аймгийн Засаг даргад эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний зураг төслийг зургийн жишиг үнийг баримтлан тооцож зураг төслийн үнийг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусган хуваарилах замаар олгосон байна.

А.3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ҮР АШИГТАЙ ТӨЛӨВЛӨХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнд хэрэгцээ шаардлагагүй, эсвэл хэрэгцээ шаардлагаас бага болон их хүчин чадалтай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Говь-Алтай аймагт эрх шилжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний 60 хувь нь шинэ, 40 хувь нь шилжих төсөл арга хэмжээ байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд орсон өөрчлөлтөөр батлагдсан, харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид Говь-Алтай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 2021 онд хэрэгжихээр шинээр батлагдсан төсөл, арга хэмжээ 100 хувь их засварын ажил, шилжих ангилалд багтан батлагдсан он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний 12 хувь нь их засварын ажил, 88 хувь нь барилга байгууламжийн ажил байна. Барилга байгууламж ангилалд батлагдсан төсөл, арга хэмжээний байршил бүгд Есөнбулаг сумд байна. Эдгээр төсөл, арга хэмжээнд хэрэгцээ шаардлагагүй, эсвэл хэрэгцээ шаардлагаас бага болон их хүчин чадалтай төсөл, арга хэмжээ байхгүй байна.



Эрх шилжин ирсэн тайлант хугацаанд шинээр хэрэгжиж захиалагч хүлээн авсан төсөл, арга хэмжээний тухайд хэрэгжсэн төсвийн дүнгээр өртгийг нэмэгдүүлэх байдлаар капиталжуулсан боловч урт хугацааны тухайд үр өгөөж бий болох барилга байгууламжийн насжилтад нөлөөлөхүйц их засварын ажил хийгдээгүй байгааг цаашдын хөрөнгө оруулалтад анхаарч төсөвлөлтийн саналд оновчтой хэлбэрийг сонгох шаардлагатай байна.

А.3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг анх батлахдаа төсөвлөлтийн шаардлагыг хангаагүйгээс тус төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх, хэрэгжих явцдаа төсөвт өртөг нэмэгдэх, эх үүсвэр хүрэлцэхгүй царцах гэх мэт сөрөг үр дагавар үүсгэсэн байна

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд тусгасан нь тайлант онд бүрэн хэрэгжүүлэх боломжгүйд хүргэсэн, барилга угсралтын ажил эхэлсэн боловч он дамжин төсөвт өртөг өсөж хэрэгжихгүй хугацаа алдсан 5 төсөл, арга хэмжээ байна. Үүнд :

- ✓ **Магадлалын ерөнхий дүгнэлт:** Ахмадын холбоо, сувиллын барилга /ГАА Есөнбулаг/, Сургуулийн спорт заалны барилга /ГАА Есөнбулаг IV сургууль/, Сургуулийн спорт заалны барилга /ГАА Бигэр сум/, Сургуулийн спорт заалны барилга /ГАА Бугат сум/, Сургуулийн спорт заалны барилга /ГАА Цогт сум Баянтоорой/, Нийтийн тээврийн автобусны буудал 10 байршил /ГАА Есөнбулаг/.

Анх 2019 онд хуульд батлагдаж хэрэгжиж эхэлсэн 4 байршилд баригдаж байгаа спорт заал төсөл, арга хэмжээ 2020 онд магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэснээр төсөвт өртөг өссөнөөр 2020, 2021 онуудад хуульд батлагдахгүй орхигдсоноор хөрөнгө оруулалтын ажил 30-40 хувийн гүйцэтгэлтэй зогссон 2022 оны хуульд батлагдсан байна.

Анх 2020 онд хуульд батлагдаж хэрэгжиж эхэлсэн Ахмадын холбоо, сувиллын барилга /ГАА Есөнбулаг/ төсөл, арга хэмжээ 2021 онд магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэснээр төсөвт өртөг 3,806.1 сая төгрөг болж өссөн ба 2022 оны хуульд орхигдсон байна.

А.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулаагүй байна. Зарим төсөл арга хэмжээнд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5¹-т заасан төсөвлөлтийн зарчмыг хангахгүйгээр санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталж байгаа нь хуулиар тодорхойлсон хугацаанд төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусахгүй байх шалтгаан болж байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан өөрчлөлтөөр Говь-Алтай аймагт хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээнээс Говь-Алтай аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлэхээр харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдаас шийдвэр ирүүлсэн 2020 оноос 2022 он хүртэл үргэлжлэх хугацаатай 8,480.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2021 онд 7,700.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 20 төсөл, арга хэмжээ байна.

Эдгээр төсөл, арга хэмжээнд 2021 онд дуусах хугацаатай 7,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6,700.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 15 төсөл, арга хэмжээ батлагдсан. Төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртөг, 2020-2021 онд гүйцэтгэгчид олгогдсон санхүүжилт, барьцаа хөрөнгийн дансанд байршсан санхүүжилт, 2022 оны хуульд батлагдсан санхүүжих дүн зэрэгт судалгаа хийхэд 2 (Нийтийн тээврийн автобусны буудал, 10 байрлал /Говь-Алтай, Есөнбулаг/) төсөл, арга хэмжээний 33.3 сая төгрөгийн төсөвт өртөг батлагдаагүй байна.

Хүснэгт 2. ТАХ-ын судалгаа (сая.төг)

	ТАХ ТОО	ТӨСӨВТ ӨРТӨГ	2020 ОН	2021 ОН	2022 ОН	-
ШИНЭ	7	1,630.0		1,630.0		
ШИЛЖИХ	8	5,470.0	300.0	5,030.0	91.7	33.3

А.3.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулаагүй байна.


Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан өөрчлөлтөөр Говь-Алтай аймагт хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Нийт батлагдсан төсөл, арга хэмжээний 65 хувь нь барилга байгууламж, 35 хувь нь их засварын ажил байна.

Б.1. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГАА ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Б.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан өөрчлөлтөөр Говь-Алтай аймагт хэрэгжихээр батлагдсан 2019 оноос 2022 он хүртэл үргэлжлэх хугацаатай 54,499.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2021 онд 21,970.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 37 төсөл, арга хэмжээнээс 2020 оноос 2022 он хүртэл үргэлжлэх хугацаатай 8,480.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2021 онд 7,700.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 20 төсөл, арга хэмжээг



¹ 29.3.5-т "Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах"

Говь-Алтай аймгийн Засаг даргад (Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 18, Боловсрол шинжлэх ухааны сайдын тушаалаар 2 төсөл арга хэмжээ) эрх шилжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэр ирүүлсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

Б.1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг тайлант онд хэрэгжих боломжийг хангах хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.



Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны 2 дугаар улиралд 10 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зөвлөмж өгчээ.

Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 6 дугаар цэцэрлэг/, Сургуулийн дотуур байрны их засвар /Говь-Алтай, Баян-Уул сум/ нэртэй 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй ба шалтгаан нь Цэцэрлэгийн барилга буулгаж шинээр барих 320 ор /ГАА Есөнбулаг 6 дугаар цэцэрлэг/, Дотуур байрны барилга буулгаж шинээр барих 160 ор /Говь-Алтай, Баян-Уул сум/ төсөл, арга хэмжээ 2022 оны хуульд батлагдсантай холбоотой байна.

Б.1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулж, батлуулж хэрэгжүүлсэн байна.

Эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1²-т заасан журмыг оновчтой сонгон худалдан авах ажиллагааг уламжлалт болон цахим хэлбэрээр зохион байгуулан нийтэд мэдээлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд шинээр хэрэгжүүлэх эрх шилжин ирсэн 10 төсөл, арга хэмжээний 20 хувь нь уламжлалт буюу цаасаар 80 хувь нь цахимаар 100 хувь нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулсан байна.

² 7.1-т Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:

7.1.1-т нээлттэй тендер шалгаруулалтын журам;

7.1.2-т тендер шалгаруулалтын онцгой журам;

7.3-т Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно.


Б.1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа оролцогчдыг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээнд оролцогчоос Сангийн яаманд гомдол гарган хангагдаж тендер шалгаруулалтын үнэлгээ дахин хийгдсэн байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг www.e-procurement.mof.gov.mn, www.govi-altai.gov.mn, www.meps.gov.mn веб сайтуудад болон өдрийн сонин, байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулан тендерийн урилга болон баримт бичгүүдийг нээлттэй ил тод нийтэлж ажилласан байна.

Б.1.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнаж, шилэн дансаар дамжуулан нийтэд мэдээлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.5³-т заасан хугацаа, Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг баримтлан цахим системээр тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг явуулсан ба Сангийн яамнаас хэрэгжилтэд цахим системээр хяналт, шинжилгээ хийсэн байна.



Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдаас Говь-Алтай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг үнэн зөв гаргаж хугацаанд нь тайлагнасан байна.

Б.2. ЗАХИАЛАГЧ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ҮР ДҮНТЭЙ ХАНГУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖИЛ ДУТМАГ БАЙНА.

Б.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн ажлын гүйцэтгэл дуусаж хүлээн авсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, төсвөөр захиалагчтай байгуулсан гэрээний дагуу үр дүнтэй гүйцэтгэсэн боловч ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтлийг дахин засварлуулах шаардлагатай байна.

Аудитын явцад тайлант хугацаанд хамаарах зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцтай танилцан холбогдох албан тушаалтны хамт газар дээр нь нүд үзэн үнэлэлт дүгнэлт

³ 49.5-т Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

өгсөн. Эдгээрээс доорх төсөл, арга хэмжээнүүдийг ажлын чанар байдлаас хамааран зайлшгүй дахин засварлах 5 төсөл, арга хэмжээг онцлон дурдаж байна.

Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 5 дугаар цэцэрлэг/ ТАХ: Тус төсөл, арга хэмжээ хуульд 2021 онд батлагдсан. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас шалтгаалан гэрээнд сунгалт хийгдсэн. Гүйцэтгэгчээр “Тана орд” ХХК ажилласан гэрээний дүн 222.4 сая төгрөг ба одоогоор 150.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон барьцаа дансанд 71.5 сая төгрөг байршиж байна. Ажлын гүйцэтгэлээс 8 төрлийн ажил хийх дутуу байхад хугацаатай үүрэг даалгавар өгч хүлээн авсан. Мөн тус барилгын агуулахын хэсгийн дээвэр чанаргүй хийгдсэнээс хана дагаж ус нэвчсэн байдалтай байна.



Баруун бүсийн уламжлалт анагаах ухааны төвийн эмнэлгийн барилгын их засвар /ГАА, Есөнбулаг сум/ ТАХ:



Тус төсөл арга хэмжээ хуульд 2021 онд батлагдсан. Ажлын гүйцэтгэл дуусаж хүлээн авсан. Гүйцэтгэгчээр “Гуулин-Эрдэнэ” ХХК ажилласан гэрээний дүн 207.9 сая төгрөг санхүүжилт бүрэн олгогдсон. Барилгын гадна өнгөлгөөний хэсэгт бага зэрэг цууралт өгсөн байна. Ашиглагчаас их засварын ажлын чанар байдлыг тодруулахад агааржуулалтгүйгээс хэвтэн эмчлүүлэгчдийн өрөөний цонх мөөгөнцөртсөн эмнэлгийн стандарт хангахгүй байгаа талаар ирүүлсэн ба аудитын багаас энэ байдал нь их засварын ажилтай биш барилгын анхны хийцтэй холбоотой байна гэж үзлээ. Харин гүйцэтгэгч гадна өнгөлгөөний хэсгийг засварлах шаардлагатай байна.

Цэцэрлэгийн барилгын их засвар /ГАА,Есөнбулаг сум 3 дугаар цэцэрлэг/ ТАХ:

Тус төсөл, арга хэмжээ хуульд 2021 онд батлагдсан. Ажлын гүйцэтгэл дуусаж хүлээн авсан. Гүйцэтгэгчээр “Трайзен” ХХК ажилласан гэрээний дүн 243.7 сая төгрөг санхүүжилт бүрэн олгогдсон. Ашиглагчаас их засварын ажлын чанар байдлыг тодруулахад дээврийн төмөр баруун талдаа 800*100 см хэмжээтэй урагдаж ханзарсан байгаа талаар албан бичиг ирүүлсэн. Их засварын ажлын явцад хийсэн захиалагчийн хяналтын материалуудтай танилцахад ажлын явцад үүссэн хүндрэлээс шалтгаалан нэмэлт ажил их хэмжээгээр хийгдсэн, засварын явцад дээврээс нуралт өгснөөр таазыг дотор талаас нь бэхэлсэн байна. Барилгын тухай хуульд заасан хугацаанд гэмтэл гарсан тул гүйцэтгэгчээр засварлуулах нөхцөл байдал бий болжээ.



“Алтай” чуулгын хуучин барилгыг “Багшийн хөгжлийн ордон” болгож өөрчлөх /ГАА,Есөнбулаг сум/ ТАХ:



Тус төсөл, арга хэмжээ нь хуульд 2020 онд батлагдсан. Гүйцэтгэгчээр “Ашид гэгээн өргөө” ХХК ажилласан гэрээний дүн 762.8 сая төгрөг санхүүжилт бүрэн олгогдсон. Ашиглагчаас ажлын гүйцэтгэлийн талаар тодруулахад хэд хэдэн хүсэлт ирсэн ба газар дээрх нөхцөл байдалтай биечлэн танилцахад цонхонд өнгөлсөн гантиг чулуун тавиур суулгах ёстой байтал өөр материалаар хийсэн байлаа. Бусад асуудлыг нэг өдрийн үзлэгээр тогтоох боломж байхгүй ба ажлын гүйцэтгэлд хямд өртөг багатай материал ашигласан байдал түгээмэл ажиглагдлаа.

Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /ГАА, Есөнбулаг сум/ ТАХ:



Тус төсөл, арга хэмжээ хуульд 2020 онд батлагдсан. Короновируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас шалтгаалан гэрээнд сунгалт хийгдсэн. Гүйцэтгэгчээр “ЭСПМ” ХХК ажилласан гэрээний дүн 194.9 сая төгрөг ба одоогоор 49.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон барьцаа дансанд 44.9 сая төгрөг байршсан 2022 оны хуульд 45.0 сая төгрөг батлагдсан. Одоогоор 5 байршилд цементэн талбай цутгагдсан боловч чанар байдал муу эхнээсээ бутарсан байдалтай байна. Захиалагчийн тухайд тус тоглоомын талбайн байршлыг тодорхой болгоогүйгээс 2 байршилд

ажил эхлээгүй, 1 байршил оновчгүй байснаас цутгасан талбай хусагдсан байна.

Илрүүлэлт:

- ✓ Захиалагчийн барилгын хяналтын нэгдсэн дүгнэлтээр хүлээн авсан “Алтай” чуулгын хуучин барилгыг “Багшийн хөгжлийн ордон” болгож өөрчлөх /ГАА,Есөнбулаг сум/, Цэцэрлэгийн барилгын их засвар /ГАА, Есөнбулаг сум 3 дугаар цэцэрлэг/, Баруун бүсийн уламжлалт анагаах ухааны төвийн эмнэлгийн барилгын их засвар /ГАА, Есөнбулаг сум/, Цэцэрлэгийн барилгын их засвар /Говь-Алтай, Есөнбулаг сум, 5 дугаар цэцэрлэг/ төсөл, арга хэмжээнд ашиглалтын явцад хэрэгжсэн төсөл арга хэмжээтэй холбоотой ус орох, цууралт өгөх, зураг төсөлд заасан материал солигдсон гэх мэт гэмтэл доголдол үүссэн
- ✓ Хүүхдийн тоглоомын талбай, 8 багт /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээ 2020 оноос хэрэгжиж байгаа боловч одоо болтол байршил тодорхой болоогүй
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо 2,293.4 сая төгрөгийн и-баримтгүй гүйлгээ хийсэн байна.

Б.2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналт үр дүн багатай байна. Тайлант хугацаанд хэрэгжиж байгаа 44 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад захиалагчийг төлөөлж аймгийн ГХБХБГ-аас үе шатны хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна. Хэдийгээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч төсөл, арга хэмжээний хэрэгжилт, чанар байдал хангалтгүй байгаа нь хяналт үр дүн багатай байгааг харуулж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа “2021 онд шинээр баригдаж байгаа барилга, байгууламжид хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж ГХБХБГ-т шинээр баригдаж байгаа барилга, байгууламжийн угсралтын явцад захиалагчийн хяналтыг цаг хугацаанд үе шаттайгаар чанартай сайн хийж гүйцэтгэх, хангагч байгууллагуудаас холбогдох техникийн нөхцөлүүдийг авсны дараа барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгож байх, барилга байгууламжийн их засварын ажлыг дууссаны дараа ажлын хэсгийн комисс ажиллахдаа Мэргэжлийн хяналтын холбогдох байцаагчдыг оруулах зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангагдаагүй байна.

Б.2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн техник, тоног төхөөрөмж хэрэглэгчид бүрэн хүрсэн байна.

Хуульд 2021 онд салбар, салбарын төсвийн ерөнхийлөн захирагчдын тоног төхөөрөмж улсын хэмжээнд төсөл, арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас 26 нэгжид 4,618.0 сая төгрөгийн 498 ширхэг тоног төхөөрөмж, Боловсрол шинжлэх ухааны яамнаас 51 нэгжид 657.0 сая төгрөгийн 200 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн ба хөрөнгийг хүлээн авч нягтлан бодох бүртгэлдээ бүртгэжээ.

Б.2.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдаж хийгдсэн боловч ажлын гүйцэтгэл, чанараас шалтгаалан хүлээн аваагүй 5 төсөл арга хэмжээ орхигдсон байна.

Аудитаар тайлант хугацаанд болон өмнөх онуудын хуульд батлагдан хэрэгжиж байгаа орхигдсон төсөл, арга хэмжээний судалгааг гаргахад эрх шилжин хэрэгжиж байгаа чанар байдал ажлын гүйцэтгэлээс шалтгаалан хүлээн аваагүй 5 төсөл, арга хэмжээ байна. (Хүснэгт) Хүснэгт 3 . Орхигдсон төсөл арга хэмжээ (сая.төг)

Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт	Ажлын гүйцэтгэл %
Ахмадын холбоо, сувиллын барилга /ГАА, Есөнбулаг сум /	“БГБС” ХХК	1,200.0	889.0	70%
Сумын төвийн шинэчлэл /ГАА, Дэлгэр сум/	“Мандал голомт” ХХК	5,000.0	5,000.0	50%
Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 /ГАА, Есөнбулаг сум/	“Ус-Алтай” ХХК	176.0	176.0	30%
Жишиг гудамж тохижилт /ГАА, Есөнбулаг сум	“Бумбат даваа” ХХК	1,000.0	849.2	
Цэцэрлэгийн барилга 100 ор /ГАА, Халиун сум /		1,166.3	666.3	30%

Илрүүлэлт:

- ✓ Ахмадын холбоо, сувиллын барилгын ажлын явцад магадлалын дүгнэлтээр гэрээ байгуулсан төсөвт өртөг 3 дахин өссөн дүнгээр хянагдсан бөгөөд тус нэмэгдсэн төсөв Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй, цаашид хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүйгээр ажил зогссон байна.

Б.3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮҮ?

Б.3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдүүлээгүй байна.

Аймгийн ГХБХБГ нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласан байна. Тайлант хугацаанд эрх шилжин ирсэн 10 төсөл, арга хэмжээг захиалагч хүлээн авсан байна. Хүлээн авсан төсөл, арга хэмжээнээс 5 төсөл, арга хэмжээний ашиглагч байгууллага сэтгэл хангалуун ямар нэгэн гомдол саналгүй талаар албан бичиг ирүүлсэн ба зайнаас хяналт тавихад мөн ямар нэгэн зөрчил дутагдал байсангүй. Харин 5 төсөл, арга хэмжээний

гүйцэтгэлийг хүлээн авсан боловч чанарын шаардлага хангаагүйн улмаас дахин ажиллах асуудал тулгарсан байна. Төсөл, арга хэмжээ

хэрэгжиж дууссан, гүйцэтгэлийг хүлээн авсан 5 төсөл, арга хэмжээний санхүүжилт олгогдоогүй байна. /Хүснэгт /

Хүлээн авсан 9 төсөл, арга хэмжээ нь батлагдсан зураг төслийн дагуу хийгдсэн ба гүйцэтгэлийн явцад зураг төсөл зохиогч хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Харин 1 төсөл, арга хэмжээ /Тонхил сумын ЕБС-ын их засвар/ газар хөдлөлийн улмаас гарсан эвдрэлд хүчитгэлийн ажил хийсэн тул зураггүй хийгдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн “Захиалагчийн хяналт хийх, техник хяналтын зардлыг захиран зарцуулах журам батлах тухай” А/49 дугаар захирамжийн 4.2⁴-т зааснаар захиалагчийн хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл төсвийн ерөнхий дансанд төвлөрөхөөр байгаа боловч энэ заалт өмнөх онуудад хэрэгжээгүй байна. Өмнөх оны аудитаар Захиалагчийн хяналтын дансны үлдэгдлийн тооцоог нийлж хяналттай зарцуулах талаар албан шаардлага өгөгдсөн боловч хэрэгжилт хангалтгүй энэ хугацаанд дансны үлдэгдэлд тооцоо нийлж ажиллаагүй байлаа. Аудитын хугацаанд Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, ГХБХБГ хоорондыг өглөг авлагын тооцоо нийлж ирүүлэх талаар албан бичиг хүргүүлж тооцоог авсан боловч хариуцсан мэргэжилтнүүд удаа дараа солигдсоны улмаас бүрэн дүүрэн тооцоо нийлж чадахгүй нөхцөл байдалтай байна. Иймд өмнөх аудитын тооцоололд тулгуурлан үлдэгдэл гаргахад өмнөх онуудад дууссан боловч захиалагчийн хяналтын зардал олгогдоогүй 124.9 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба энэ үлдэгдэлд Төрийн аудитын байгууллагаас дахин хяналт тавих албан шаардлага өгсөн 35.6 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ багтсан байна.

Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс орон нутагт хэрэгжсэн барилга угсралтын болон их засварын ажлын чанар ашиглалтын шаардлага хангаагүй, Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, норматив, стандарттай нийцэхгүй

Хүснэгт 4.

Хураангуй

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР БАЙРШИЛ			АШИГЛАГЧААС ГОМДОЛ САНАЛ БАЙХГУЙ ТАЛААР АЛБАН БИЧИГ ИРСЭН	ШААРДЛАГА ХАНГААГҮЙН УЛМААС ДАХИН АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ	САНХҮҮЖИЛТ ДУТУУ БАРЬЦАА ДАНСАНД	2022 ОНЫ ХУУЛЬД ТУССАН ДҮН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАСВАР /ГАА, ЦЭЦЭРЛЭГ/	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ III	ИХ		+		
ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАСВАР /ГАА, ЦЭЦЭРЛЭГ/	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ V	ИХ		+	+	
ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАСВАР /ГАА, ЦЭЦЭРЛЭГ/	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ VIII	ИХ	+			
СУРГУУЛИЙН ЗАСВАР /ГАА, ТӨГРӨГ СУМ/	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ	ИХ		+		+
СОЁЛЫН ТӨВИЙН ЗАСВАР /ГАА, ЭРДЭНЭ СУМ/	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ	ИХ	+			+
СОЁЛЫН ТӨВИЙН ЗАСВАР /ГАА, ЧАНДМАНЬ СУМ/	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ	ИХ	+			+
СОЁЛЫН ТӨВИЙН ЗАСВАР /ГАА, ДЭЛГЭР СУМ/	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ	ИХ	+			+
БАРУУН БҮСИЙН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН ЭНЭЛГИЙН ЗАСВАР /ГАА, ЕСӨНБУЛАГ СУМ/	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ	ИХ		+		
“АЛТАЙ” ЧУУЛГЫН ХУУЧИН БАРИЛГЫГ БАГШИЙН ХӨГЖЛИЙН ОРДОН БОЛГОЖ ӨӨРЧЛӨХ /ГАА, ЕСӨНБУЛАГ СУМ/	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ	ИХ		+		
ТОНХИЛ СУМЫН ЗАСВАР	БАРИЛГЫН ЕСӨНБУЛАГ	ИХ	+			

⁴ Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу төсвийн жил дуусахад захиалагчийн хяналтын зардлаас зарцуулагдаагүй үлдэгдлийг тухай шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

байна. Үүнд хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, барилгын хяналтын мэргэжилтэн тогтвор суурьшилтай ажиллахгүй олон дахин солигдож байгаа байдал мөн тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Илрүүлэлт:

- ✓ Өмнөх онуудад дууссан боловч захиалагчийн хяналтын зардал олгогдоогүй 89.6 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Б.3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.



Тайлант хугацаанд Говь-Алтай аймгийн Засаг даргад эрх шилжин ирсэн гүйцэтгэл хийгдэж байгаа 17 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр төсөл, арга хэмжээнд харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдаас хуульд тусгагдсан 2021 онд санхүүжих дүн буюу 6,921.3 сая төгрөг бүрэн төвлөрсөн ба үүнээс гүйцэтгэгчид ажлын гүйцэтгэлийн дагуу 5,578.1 сая төгрөг олгож аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд гүйцэтгэл дутуу 1,343.2 сая

төгрөгийн үлдэгдэл байршиж байна. Төсөл, арга хэмжээ хэрэгжиж хүлээлгэн өгсөн боловч санхүүжилтаа бүрэн аваагүй 4 гүйцэтгэгч байна.

Б.3.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд ТЕЗ-ын дотоод аудитын нэгж хяналт шалгалт хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69.1⁵, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тайлант хугацаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Б.4 УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙН ЖИЛД БАТЛАГДСАН САНХҮҮЖИЛТИЙГ БҮРЭН АШИГЛАХ ЗОРИЛГООР ЗАСГИЙН ГАЗРААС ГАРСАН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Б.4.1. Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний 1,614.7 сая төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

Аймгийн Га.Хөрөнгө оруулалтын барьцаа нэртэй 100050000350 тоот төрийн сангийн бүртгэлийн данс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,638.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнийг хөрөнгө оруулалтын нэр төрлөөр ангилбал улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээтэй холбоотой 15 төсөл арга хэмжээний 1,614.6 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээтэй холбоотой 2 төсөл, арга хэмжээний 24.3 сая төгрөг байршиж байна.

Дээрх дансны үлдэгдлийн судалгааг гаргахад Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу анх 800.0 сая төгрөг, 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу 14.0 сая төгрөг, 2021 оны 397 дугаар тогтоолын дагуу 1,343.2 сая төгрөг байршиж байна.

⁵ 69.1-т Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

Төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлд хяналт тавиагүй атал тайлант онд Бигэр, Бугат сумын сургуулийн спорт заалны гүйцэтгэгчид 112.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Тус төсөл арга хэмжээний ажлын явцыг 30-40 хувь гэж үнэлсэн боловч зурган харьцуулалд хийхэд дараах байдалтай байна. (Зураг 2)

Хүснэгт 5. Олгосон санхүүжилт харьцуулалт (сая.төг)

Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг		Олгосон санхүүжилт	Ажлын явц
	2019 он	2022 он		
Сургуулийн спорт заалны барилга /ГАА, Есөнбулаг сум, IV сургууль /	250.0	577.4	175.0	40%
Сургуулийн спорт заалны барилга /ГАА, Бигэр сум/	250.0	616.8	174.4	30%
Сургуулийн спорт заалны барилга /ГАА, Бугат сум/	250.0	573.5	250.0	30%
Сургуулийн спорт заалны барилга /ГАА, Цогт сум, Баянтоорой /	250.0	702.7	247.5	40%

Зураглал 2. Ажлын явц зурган харьцуулалт



Га.Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 2020 оны хуульд батлагдсан Соёлын төвийн барилгын их засвар /ГАА, Хөхморьт сум/ төсөл, арга хэмжээний 65.9 сая төгрөг байршиж байна. Аудитын үеэр ашиглагч болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч нараас тус ажлын явц, чанарыг тодруулахад барилгын насжилт дуусаж цаашид ашиглаж болохгүй талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан, хийж байгаа засвар батлагдсан зургийн дагуу явж байгаа боловч засал авахгүй байгаа талаар мэдээлэл ирүүлсэн тул хөрөнгө оруулалтын үнэ цэнэ үр ашгийн тооцоог дахин хийж зүй зохистой байдлаар шийдвэрлэх шаардлага тулгарсан байна.

Илрүүлэлт:

- ✓ Ажлын гүйцэтгэлд хяналт тавилгүйгээр 112.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- ✓ Аймгийн 4 сумд баригдаж байгаа спорт заалны эхний санхүүжилт 2019 онд БШУЯ-аас санхүүжсэн байхад тус 4 төсөл арга хэмжээний 2022 онд санхүүжих 1,470.4 сая төгрөгийн санхүүжилт нь Монгол улсын Ерөнхий сайдын багцад Биеийн тамир спортын улсын улсын хорооны төсөвт тусгагдсан.

Б.4.2. Өмнөх онуудад Засгийн газраас ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгөөс гүйцэтгэгчид гэрээний дүнгээс илүү төлбөр шилжүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний тухайн тайлант хугацаанд төсвийн тухай хуульд батлагдсан санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан олгохыг Засгийн газраас эрх шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгажээ.

Энэ дагуу Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу байршсан 256.7 сая төгрөг, 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу байршсан 14.8 сая төгрөг, 2021 оны 397 дугаар тогтоолын дагуу байршсан 1,343.2 сая төгрөгийн нийт 1,614.7 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт байршиж байна.

Барьцаа дансанд 2018 оны хуульд батлагдаж хэрэгжсэн 2 (Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /ГАА, Алтай сум/, Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /ГАА, Чандмань сум/) төсөл, арга хэмжээний 6.0 сая төгрөг байна.

Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /ГАА, Алтай сум/ төсөл, арга хэмжээг 2022 онд хүлээн авсан ба гэрээний гүйцэтгэлийг гаргахад гүйцэтгэгчид 5.1 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.

Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /ГАА, Чандмань сум/ төсөл арга хэмжээний магадлашгүй ажлын зардалд хуваарилагдсан 4.1 сая төгрөгийн ажил хийгдээгүй, Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /ГАА, Алтай сум/ төсөл арга хэмжээний зохиогчийн хяналтын зардал болох 1.9 сая төгрөг тус тус барьцаа дансанд байршсан боловч төсвийн ерөнхий данс руу төвлөрүүлээгүй байна

Илрүүлэлт:

- ✓ Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /ГАА, Алтай сум/ төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид 5.1 сая төгрөг илүү шилжүүлсэн
- ✓ Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /ГАА, Чандмань сум/ төсөл арга хэмжээний магадлашгүй ажлын зардалд хуваарилагдсан 4.1 сая төгрөгийн ажил хийгдээгүй, Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /ГАА, Алтай сум/ төсөл арга хэмжээний зохиогчийн хяналтын зардал болох 1.9 сая төгрөг тус тус барьцаа дансанд байршсан боловч төсвийн ерөнхий данс руу төвлөрүүлээгүй байна.

Б.5 УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН БАЙНА.

Б.5.1. Ашиглалтад хүлээн авсан 1 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.

Эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээнээс 2021 онд дуусах 15 төсөл, арга хэмжээ байснаас 2 төсөл, арга хэмжээ нь хэрэгжээгүй 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид ажлын гэрээгээ короновируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас шалтгаалан 2022 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл сунгасан байна. Үлдсэн 10 төсөл, арга хэмжээг захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан байна. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг ашиглагч данс бүртгэлд тусгасан байдлыг үзэхэд Тонхил сумын ЕБС-ын их засварын ажлыг бүртгэлд тусган капиталжуулаагүй байна.

Илрүүлэлт:

- ✓ Тонхил сумын ЕБС-ын 49.5 сая төгрөгийг их засварын ажлыг данс бүртгэлд тусгаагүй

Б.5.2. Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд болон он дамжин хэрэгжиж байгаа 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэнээс 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй орхигдсон байна.

Хуульд 2021 онд хэрэгжихээр батлагдсан харьяа төсвийн ерөнхийлөн захирагч нараас Говь-Алтай аймгийн Засаг даргад эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээнд тайлант онд төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээ байхгүй. Харин төсөл, арга хэмжээг анх хэрэгжүүлж эхлэхдээ төсөвлөлтийн шаардлагыг	Хүснэгт 6.	Харьцуулалт		(сая.төг)	
	Төсөл, арга хэмжээний нэр		Хэрэгжих он		БТӨ
	Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий өгий нуур сум /		2021	2022	1,620.0
	Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий Булган сум /		2022	2023	1,600.0
	Сургуулийн спорт заалны барилга /Завхан, Отгон сум /		2022	2023	1,693.0
	Сургуулийн спорт заалны барилга /Завхан, Цагаанхайрхан сум /		2022	2023	1,232.1
	Сургуулийн спорт заалны барилга /Увс, Сагил сум /		2020	2022	1,250.0

хангаагүй, зураг төсвийг магадлалаар батлуулаагүйгээс 2019 онд эхэлсэн боловч 2020-2021 онд ажил хийгдээгүй 4 сумын сургуулийн спорт заалны барих төсөл, арга хэмжээ 2022 оны хуульд батлагдсан байна. Адил төрлийн спорт заалны батлагдсан төсөвт өртөгтэй харьцуулахад бага байгаа боловч анх батлагдсан төсөвт өртөг нэмэгджээ.

Хүснэгт 7. Нэмж батлагдсан төсөв өртөг (сая.төг)

Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг		Нэмэгдсэн дүн
	2019 он	2022 он	
Сургуулийн спорт заалны барилга /ГАА, Есөнбулаг сум, IV сургууль /	250.0	577.4	327.4
Сургуулийн спорт заалны барилга /ГАА, Бигэр сум/	250.0	616.8	366.8
Сургуулийн спорт заалны барилга /ГАА, Бугат сум/	250.0	573.5	323.5
Сургуулийн спорт заалны барилга /ГАА, Цогт сум, Баянтоорой /	250.0	702.7	452.7

Хуульд 2020 оноос батлагдаж хэрэгжсэн ахмадын холбоо, сувиллын барилга /ГАА, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээний төсөвт өртөг өссөний улмаас 2022 оны хуульд тусгагдаагүй орхигдсон байна.

Хүснэгт 8. Төсөвт өртөг нэмэгдсэнээр орхигдсон барилгын судалгаа (сая.төг)

Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Олгосон санхүүжилт	Магадлал хийгдсэн төсөвт өртөг
Ахмадын холбоо, сувиллын барилга /ГАА, Есөнбулаг/	1,200.0	889.0	3,806.1

Б.5.3. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт удаашралтай бодитоор гарсан үр дүн багатай байна.

Төрийн аудитын байгууллагын статистик мэдээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн өмнөх онуудын аудитаар өгөгдсөн 10.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,356.6 сая төгрөгийн 8 заалт албан шаардлага, 18,079.6 сая төгрөгийн 8 заалт зөвлөмж, 3,518.8 сая төгрөгийн зөрчлийг Үндэсний аудитын газарт уламжилсан шийдвэр бүртгэлтэй байна. Үүнээс ГХБХБГ-т өгсөн 1 заалт албан шаардлага, 18,079.6 сая төгрөгийн 8 заалт зөвлөмж, 3,518.8 сая төгрөгийн

Үндэсний аудитын газарт уламжилсан асуудлын хэрэгжилт хангагдсан. 10.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,356.6 сая төгрөгийн 7 заалт албан шаардлагын хэрэгжилт хангагдаагүй байна.

Өмнөх онд гүйцэтгэл чанарын шаардлага хангахгүй байгаа талаар албан шаардлага өгсөн 4 төсөл арга хэмжээг аудитын хугацаанд газар дээрх нь ажиллан хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Манай байгууллагаас 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өгсөн 01/188 дугаартай “Зөрчил арилгах тухай” албан шаардлага, өгсөн заалт: “...төсөл, арга хэмжээний чанар байдалд хяналт хийж зөрчлийг арилгах” заалтын хэрэгжилтийг давтан үзэхэд:

- ✓ Дэлгэр сумын төвийн шинэчлэл төсөл, арга хэмжээг 2014 оноос хойш гүйцэтгэж байгаа боловч дуусгаж хүлээлгэн өгөөгүй байна.

Тайлант хугацаанд төсөл, арга хэмжээний 2,496.1 сая төгрөгт ногдох ажил буюу нийт ажлын 50 хувийг хүлээн авсан ба ашиглагчийн албан тоотод дурдсанаар гэрэлтүүлэг, цэвэрлэх байгууламж, цэвэр бохир усны шугам угсралтын ажил хийгдээгүй байна.



- ✓ ...Баян-Уул, Дарив сумын сургууль...барилгын чанар байдал алдагдсан гүйцэтгэгчээр засвар хийлгүүлэх шаардлагатай байна..., ...Арвин бэлт ХХК-ын гүйцэтгэсэн Дарив сумын ЭМТ-ийн ...гадна талбайд чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулагдаагүй...

Тайлант хугацаанд тус төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид дахин ажиллаагүй илэрсэн зөрчил арилаагүй байлаа.



Дарив сумын ЭМТ зураг

Дарив сумын ЕБС зураг

Баян-Уул сумын ЕБС зураг

- ✓ ...Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 төслийн хүрээнд усан оргилуур усан хангамжийн 176.0 сая төгрөгийн санхүүжилтийг “Ус-Алтай ХХК-д бүрэн олгосон боловч хэрэгжээгүй...

Тайлант хугацаанд тус төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажил байхгүй байна. Энэ асуудал хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж дутуу ажлыг гүйцэтгүүлэхээр шийдвэр гарсан боловч одоогоор ажил хийгдээгүй байна.

- ✓ ... орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сулжээ /ГАА,Есөнбулаг сум Солонго хороолол/ төсөл, арга хэмжээг “Түмэндэлгэрэх” ХХК гүйцэтгэсэн. Ажлыг гүйцэтгэхдээ “Солонго” хорооллын засмал зам сэтлэх зөвшөөрөл авч буцаан засварлах ажлаа хийгээгүй...

Тайлант хугацаанд “Солонго хорооллын засмал замын сэтэлсэн хэсэг нөхөх ажил хийгдээгүй байлаа.



Аймгийн Засаг даргаас өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг хангахаар үе шаттай ажил зохион байгуулж өөрийн дотоод аудитын нэгж болон хуулийн байгууллагад хандсан талаар 2022 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн 2/475 дугаар албан бичигт дурдагдаж хавсралтаар нотлох баримтыг ирүүлсэн байна.

Аудитын байгууллагын шийдвэрийг цаг хугацаанд нь ханган хамтарч ажиллаагүйгээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс иргэд олон нийтийн хүртэх үр өгөөж буурах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилт удаашрах улмаар нэгэнт эхэлсэн ажлын төсөвт өртөг өсөх, үргүй зардал гарах, муу гүйцэтгэгчтэй олон удаагийн гэрээ байгуулах гэх мэтээр төсвийн зардал нэмэгдэх шалтгаан болж байгааг онцгойлон анхаарч өгсөн шийдвэр болон түүний хэрэгжилтэд ач холбогдол өгч хамтарч ажиллах зайлшгүй шаардлага тулгарсан байна.

Б.5.4. Улсын төсвийн хөрөнгөөр тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийгдээгүй.

Тайлант хугацаанд эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд шинээр хэрэгжсэн ажлууд 100 хувь барилгын их засварын ажил хийгдсэн. Өмнөх оноос шилжиж ирсэн эрх шилжсэн ажлын тухайд төсөвт байгууллагын барилга байгууламжийг сайжруулах өргөтгөх ажил хийгдсэн. Эдгээр төсөл, арга хэмжээнүүдэд эдийн засгийн өсөлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ байсангүй.

Б.5.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөгөөр дэд бүтцийн салбарын хүчин чадал нэмэгдээгүй байна.

Тайлант хугацаанд эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд дэд бүтцийн салбарын хүчин чадалтай холбоотой төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй болно.

УТХО-ААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ, ЦААШИД ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БИЙ БОЛГОХ АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Дүгнэлтэд үндэслээд Үндэсний аудитын газарт нэгдсэн байдлаар шийдвэрлэх 2,359.4 сая төгрөгийн 2 санал хүргүүлж аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2 заалт зөвлөмж, аймгийн засаг даргад 100.7 сая төгрөгийн 3 заалт төлбөрийн акт, 2,455.4 сая төгрөгийн 4 заалт албан шаардлага хүргүүлээ.

Үндэсний аудитын газарт уламжилсан санал:



Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл арга хэмжээ нь 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, "БГБС" ХХК-тай 1,199.7 сая төгрөгөөр гэрээ байгуулаад 889.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн бөгөөд зураг төсөвт өөрчлөлт орж 2021 онд зураг төсөвт магадлал хийлгэж 3,806.1 сая төгрөгөөр хянагдаж баталгаажсан байна. Төсөвт өртөг 3 дахин өссөн бөгөөд нэмэгдсэн төсөвт өртөг нь Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй, цаашид хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүйгээр ажил зогссон байна.



2019 оны Төсвийн тухай хуульд БШУСЯ-ны багцад батлагдан хэрэгжиж эхэлсэн XII.3.1.15 Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/, XII.3.1.16 Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/, XII.3.1.17 Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, XII.3.1.18 Спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/ төсөл арга хэмжээ нь 2022 оны Төсвийн тухай хуульд Монгол Улсын Ерөнхий сайдын багц, Биеийн тамир спортын газрын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамрагдан III.1.1.10 Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/, III.1.1.11 Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/, III.1.1.12 Спорт заалны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/, III.1.1.13 Спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/ гэж төсөв захирагч өөрчлөгдөн батлагдсан боловч санхүүжилтгүй, хэрэгжилт зогссон байдалтай байна.

Иймд дээрх асуудлуудыг шийдвэрлэх талаар нэгдсэн тайланд тусгаж, холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагчид шийдвэр гаргаж өгнө үү.

Аймгийн Засаг даргад өгөх албан шаардлага:



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид олгосон санхүүжилтад худалдан авалтын И баримтыг нөхөн шивүүлэх



Захиалагчтай байгуулсан гэрээний заалтыг хэрэгжүүлж чанаргүй, дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгүүлэх



Хөрөнгө оруулалтаар хийгдсэн сайжруулалтыг данс бүртгэлд тусгах



Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

Аймгийн Засаг даргад өгөх төлбөрийн акт:



Гэрээний дүнгээс илүү шилжүүлсэн 5.1 сая төгрөгийг орон нутгийн орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх



Магадлашгүй ажлын зардал, зохиогчийн хяналтын зардлын нийт 6.0 сая төгрөгийг Төрийн сан дахь орон нутгийн ерөнхий орлогын 100050000910 тоот дансанд төвлөрүүлэх



Өмнөх онуудад дуусаж хүлээн авсан ажлуудын олгогдоогүй захиалагчийн хяналтын зардал 89.6 сая төгрөгийг Төрийн сан дахь орон нутгийн ерөнхий орлогын 100050000910 тоот дансанд төвлөрүүлэх.

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт өгөх зөвлөмж:



Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа гүйцэтгэгчийн өмнөх ажлын гүйцэтгэлийг харгалзан үзэх



Хийгдэж байгаа их засварын ажлыг данс бүртгэлд тусгахдаа тухайн барилга байгууламжийн насжилтад нөлөөлсөн нөлөөллийг харгалзан үзэх талаар нэгж байгууллагад мэргэжлийн байгууллагатай хамтран арга зүйн зөвлөгөө өгч хэрэгжилтийг хангах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Холбогдох байгууллагын санал:



АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Х.ТҮВШИНБАЯРТ

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлтийг зөвшөөрөв.

Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх талаар анхаарч хамтран ажиллах болно.



О.АМГАЛАНБААТАР

020.1000550

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a full page of white paper with horizontal dotted lines, typical of notebook paper. The lines are evenly spaced and run across the width of the page. There is no handwriting or other markings on the paper.